ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2026/025/-НА-СТА-ТТЗ**

**ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Адъяасүрэн
Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

## АГУУЛГА

**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**..........3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** 5
**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**..........10
**3.3 Зөвлөмж..........10**
**4. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл..........11**
**5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..........11

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн газар |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.03.24 № 01/253

танай ____________-ны № ______________-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Б.БАТТҮШИГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, 4 орон нутгийн тусгай сан, 1 төрийн сангийн нэгж нийт 11 тайлан нэгтгэгдсэн байна. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь гүйцэтгэл үр, дүнгээр санхүүжих 4 байгууллагын орон нутгаас баталсан төсвийн хүрээнд тайлагнаж нэгтгэлд оруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд Баянцогт сумын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 19 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас 104,056.6 мянган төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй бөгөөд 14 төсөл арга хэмжээнд 340,938.7 мянган төгрөгийн гэрээ байгуулагдаж, 276,360.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Баянцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 19-ний 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 21 зорилт 182 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 92,29%-тай буюу “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

4126020651

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | 1,064,007.95 | 1,175,581.24 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 3а, 3б | 630,633.06 | 729,703.07 |
| **33** | **АВЛАГА** | 5а, 5б, 6а, 6б | 345,038.78 | 334,230.44 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 8а, 8б, 8в | 74,258.77 | 75,295.52 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 9а | 14,077.34 | 36,352.21 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | 2,027,934.97 | 2,444,616.67 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 12а, 12б, 12в | 2,027,934.97 | 2,444,616.67 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | 3,091,942.92 | 3,620,197.9 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | 2,951.05 | 52,109.83 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | 2,951.05 | 52,109.83 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | 3,088,991.87 | 3,568,088.08 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | 3,088,991.87 | 3,568,088.08 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | 3,091,942.92 | 3,620,197.9 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,863,070.12 | 2,616,359.97 |
| **11** | ТАТВАРЫН ОРЛОГО | 664,613.18 | 577,447.46 |
| **110** | Орлогын албан татвар | 384,802.19 | 418,201.96 |
| **1100** | Хувь хүний орлогын албан татвар | 384,802.19 | 418,201.96 |
| **113** | Хөрөнгийн албан татвар | 52,855.92 | 73,700.51 |
| **118** | Бусад татвар, төлбөр, хураамж | 226,955.07 | 85,544.99 |
| **12** | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 508,561.89 | 2,038,912.52 |
| **122** | Тусламжийн орлого | 5,370.5 | 1,103,902.75 |
| **13** | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,689,895.05 | 0 |
| **II** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,198,014.4 | 2,186,178.99 |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,733,705.81 | 1,862,022.8 |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,691,056.74 | 1,804,427.9 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 646,873.72 | 792,228.34 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 80,099.01 | 102,658.42 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 503,811.89 | 527,427.68 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 30,196.01 | 43,312.04 |
| **2105** | Нормативт зардал | 147,466.1 | 161,773.51 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 19,299.87 | 63,823.6 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 8,165.6 | 7,316.9 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,741.81 | 2,169.42 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 250,402.72 | 103,717.99 |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 42,649.07 | 57,594.9 |
| **22** | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 464,308.59 | 324,156.19 |
| **III** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 665,055.72 | 430,180.98 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 0 | 3,067.72 |
| **V** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0 | 141.08 |
| **VII** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | 0 | 2,926.64 |
| **VI** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 665,055.72 | 433,107.62 |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон / мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 2,582,480.56 | 2,283,497.26 |
| **11** | ТАТВАРЫН ОРЛОГО | 664,613.18 | 577,447.46 |

| | | | |
|---|---|---|---|
| **110** | Орлогын албан татвар | 384,802.19 | 418,201.96 |
| **113** | Хөрөнгийн албан татвар | 52,855.92 | 73,700.51 |
| **118** | Бусад татвар, төлбөр, хураамж | 226,955.07 | 85,544.99 |
| **1180** | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 3,685.6 | 7,373.63 |
| **1181** | Газрын төлбөр | 158,034.08 | 75,484.99 |
| **1182** | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 65,235.4 | 2,686.37 |
| **12** | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 227,352.33 | 1,706,049.8 |
| **120** | Нийтлэг татварын бус орлого | 221,981.83 | 239,199.65 |
| **122** | Тусламжийн орлого | 5,370.5 | 1,103,902.75 |
| **13** | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 0 | 362,947.4 |
| | | 1,690,515.05 | 0 |
| **II** | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,562,046.23 | 1,818,539.99 |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,562,046.23 | 1,818,539.99 |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,519,248.51 | 1,761,144.59 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 643,568.77 | 794,926.58 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 78,577.06 | 100,088.78 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 503,811.89 | 526,893.74 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 26,494.85 | 24,208.57 |
| **2105** | Нормативт зардал | 1,300 | 1,772.8 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 24,033.57 | 77,245.6 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 7,465.6 | 6,796.9 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 41,885.35 | 26,435.41 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 192,111.4 | 202,776.21 |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 42,797.72 | 57,395.4 |
| **III** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 1,020,434.34 | 464,957.27 |
| **V** | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 624,170.43 | 365,373.76 |
| **22** | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 624,170.43 | 365,373.76 |
| **2200** | Дотоод эх үүсвэрээр | 624,170.43 | 365,373.76 |
| **VI** | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -624,170.43 | -365,373.76 |
| **23** | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 943.93 | 513.5 |
| **VII** | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -943.93 | -513.5 |
| **VIII** | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 395,319.97 | 99,070.01 |
| **101** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 235,313.09 | 630,633.06 |
| **20** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 630,633.06 | 729,703.07 |
| | | | |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,423,936.14 | 2,423,936.14 |
| **2** | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,423,936.14 | 2,423,936.14 |
| **3** | Тайлант үеийн үр дүн | 665,055.72 | 665,055.72 |
| **9** | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,088,991.87 | 3,088,991.87 |
| **10** | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 3,088,991.87 | 3,088,991.87 |
| **11** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -3,193.19 | -3,193.19 |
| | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,085,798.67 | 3,085,798.67 |
| **13** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 49,181.78 | 49,181.78 |
| **19** | Тайлант үеийн үр дүн | 433,107.62 | 433,107.62 |
| **20** | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,568,088.08 | 3,568,088.08 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 1,973,069.9 | 1,984,368.9 | (11,299.0) | 100.6% |
| **11** | Татварын орлого | 507,239.1 | 577,447.5 | (70,208.4) | 113.8% |
| **110** | Орлогын албан татвар | 397,292.4 | 418,202.0 | (20,909.6) | 105.3% |
| **1100** | Хувь хүний орлогын албан татвар | 397,292.4 | 418,202.0 | (20,909.6) | 105.3% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **110001** | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 320,000.0 | 336,438.6 | (16,438.6) | 105.1% |
| **110002** | Үйл ажиллагааны орлого | 15,000.0 | 19,637.0 | (4,637.0) | 130.9% |
| **110003** | Хөрөнгийн орлого | 58,292.4 | 42,552.0 | 15,740.4 | 73.0% |
| **110004** | Хөрөнгө борлуулсны орлого | 3,500.0 | 5,912.0 | (2,412.0) | 168.9% |
| **110006** | Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал | 500.0 | 13,662.4 | (13,162.4) | 2732.5% |
| **113** | Хөрөнгийн албан татвар | 44,830.0 | 73,700.5 | (28,870.5) | 164.4% |
| **113001** | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 19,000.0 | 46,168.2 | (27,168.2) | 243.0% |
| **113002** | Бууны албан татвар | 830.0 | 960.0 | (130.0) | 115.7% |
| **113004** | Малд ногдуулах албан татвар | 25,000.0 | 26,572.3 | (1,572.3) | 106.3% |
| **118** | Бусад татвар, төлбөр, хураамж | 65,116.7 | 85,545.0 | (20,428.3) | 131.4% |
| **1180** | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 2,800.0 | 7,373.6 | (4,573.6) | 263.3% |
| **118001** | Улсын тэмдэгтийн хураамж | 800.0 | 4,973.6 | (4,173.6) | 621.7% |
| **118009** | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 2,000.0 | 2,400.0 | (400.0) | 120.0% |
| **1181** | Газрын төлбөр | 54,916.7 | 75,485.0 | (20,568.3) | 137.5% |
| **118101** | Газрын төлбөр | 54,916.7 | 75,485.0 | (20,568.3) | 137.5% |
| **1182** | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 7,400.0 | 2,686.4 | 4,713.6 | 36.3% |
| **118201** | Ойн нөөц ашигласны төлбөр | 7,400.0 | 2,686.4 | 4,713.6 | 36.3% |
| **12** | Татварын бус орлого | 1,465,830.8 | 1,406,921.5 | 58,909.3 | 96.0% |
| **120** | Нийтлэг татварын бус орлого | 113,178.0 | 56,292.1 | 56,885.9 | 49.7% |
| **120003** | Торгуулийн орлого | 8,000.0 | 27,846.0 | (19,846.0) | 348.1% |
| **120004** | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 103,678.0 | 26,504.9 | 77,173.1 | 25.6% |
| **120005** | Түрээсийн орлого | 1,500.0 | 1,882.0 | (382.0) | 125.5% |
| **120009** | Бусад орлого | - | 59.2 | (59.2) | |
| **122** | Тусламжийн орлого | 987,682.0 | 987,682.0 | - | 100.0% |
| **122003** | Аймаг нийслэлээс авсан татаас | 987,682.0 | 987,682.0 | - | 100.0% |
| **123** | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 364,970.8 | 362,947.4 | 2,023.4 | 99.4% |
| **123002** | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 364,970.8 | 362,947.4 | 2,023.4 | 99.4% |
| **II** | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 468,648.8 | 1,817,241.3 | (1,348,592.5) | 387.8% |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | (162,669.9) | 1,513,757.8 | (1,676,427.7) | -930.6% |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,705,977.5 | 1,516,775.8 | 189,201.7 | 88.9% |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 731,766.6 | 703,169.7 | 28,596.9 | 96.1% |
| **210101** | Үндсэн цалин | 415,873.9 | 398,684.2 | 17,189.7 | 95.9% |
| **210102** | Нэмэгдэл | 289,404.9 | 277,997.8 | 11,407.1 | 96.1% |
| **210104** | Урамшуулал | 14,583.8 | 14,583.7 | 0.1 | 100.0% |
| **210105** | Гэрээт ажлын хөлс | 11,904.0 | 11,904.0 | - | 100.0% |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 91,470.9 | 88,396.4 | 3,074.5 | 96.6% |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 62,200.2 | 60,661.2 | 1,539.0 | 97.5% |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 7,317.7 | 7,073.9 | 243.8 | 96.7% |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 3,658.8 | 3,537.8 | 121.0 | 96.7% |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 3,658.8 | 3,411.6 | 247.2 | 93.2% |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 14,635.4 | 13,711.9 | 923.5 | 93.7% |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 529,917.9 | 526,893.7 | 3,024.2 | 99.4% |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 52,401.4 | 49,960.0 | 2,441.4 | 95.3% |
| **210302** | Түлш, халаалт | 474,756.5 | 474,436.2 | 320.3 | 99.9% |
| **210303** | Цэвэр, бохир ус | 2,760.0 | 2,497.5 | 262.5 | 90.5% |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 26,147.7 | 17,925.4 | 8,222.3 | 68.6% |
| **210401** | Бичиг хэрэг | 3,196.5 | 2,470.0 | 726.5 | 77.3% |
| **210402** | Тээвэр, шатахуун | 18,400.0 | 12,157.7 | 6,242.3 | 66.1% |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,751.2 | 1,911.5 | 839.7 | 69.5% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210405** | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,800.0 | 1,386.2 | 413.8 | 77.0% |
| **2105** | Нормативт зардал | 12,394.0 | 1,772.8 | 10,621.2 | 14.3% |
| **210503** | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 12,394.0 | 1,772.8 | 10,621.2 | 14.3% |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 119,589.5 | 94,217.3 | 25,372.2 | 78.8% |
| **210601** | Багаж, техник, хэрэгсэл | 34,082.0 | 26,732.5 | 7,349.5 | 78.4% |
| **210604** | Урсгал засвар | 85,507.5 | 67,484.8 | 18,022.7 | 78.9% |
| **2107** | Томилолт, зочны зардал | 10,800.0 | 6,796.9 | 4,003.1 | 62.9% |
| **210702** | Дотоод албан томилолт | 10,800.0 | 6,796.9 | 4,003.1 | 62.9% |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 112,562.5 | 33,808.4 | 78,754.1 | 30.0% |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 110,300.0 | 33,370.0 | 76,930.0 | 30.3% |
| **210802** | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,800.0 | - | 1,800.0 | 0.0% |
| **210803** | Даатгалын үйлчилгээ | 150.0 | 125.9 | 24.1 | 83.9% |
| **210804** | Тээврийн хэрэгслийн татвар | 191.5 | 191.5 | - | 100.0% |
| **210805** | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 121.0 | 121.0 | - | 100.0% |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 71,328.4 | 43,795.2 | 27,533.2 | 61.4% |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 69,528.4 | 42,782.4 | 26,746.0 | 61.5% |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,800.0 | 1,012.8 | 787.2 | 56.3% |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | (1,868,647.4) | (3,017.9) | (1,865,629.5) | 0.2% |
| **2131** | Засгийн газрын урсгал шилжүүлэг | (1,928,965.4) | (60,413.3) | (1,868,552.1) | 3.1% |
| **213103** | Төсвийн санхүүжилт | (1,928,965.4) | (60,413.3) | (1,868,552.1) | 3.1% |
| **2132** | Бусад урсгал шилжүүлэг | 60,318.0 | 57,395.4 | 2,922.6 | 95.2% |
| **213204** | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,800.0 | 450.0 | 1,350.0 | 25.0% |
| **213205** | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 55,518.0 | 55,518.0 | - | 100.0% |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,000.0 | 1,427.4 | 1,572.6 | 47.6% |
| **22** | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 527,640.7 | 302,970.0 | 224,670.7 | 57.4% |
| **220001** | Барилга байгууламж | 197,000.0 | 147,799.2 | 49,200.8 | 75.0% |
| **221001** | Их засвар | 40,978.8 | 11,978.7 | 29,000.1 | 29.2% |
| **222001** | Тоног төхөөрөмж | 85,000.0 | 72,392.1 | 12,607.9 | 85.2% |
| **223001** | Бусад хөрөнгө | 204,661.9 | 70,800.0 | 133,861.9 | 34.6% |
| **23** | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 103,678.0 | 513.5 | 103,164.5 | 0.5% |
| **230001** | Эргэж төлөгдөх зээл | 103,678.0 | 513.5 | 103,164.5 | 0.5% |
| **8** | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 1,504,421.1 | 167,127.6 | 1,337,293.5 | 11.1% |
| **9** | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (1,504,421.1) | (167,127.6) | (1,337,293.5) | 11.1% |
| **7** | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (1,504,421.1) | (167,127.6) | (1,337,293.5) | 11.1% |
| **4** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 519,914.2 | (519,914.2) | |
| **5** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 606,698.2 | (606,698.2) | |
| **6** | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 60 | 58 | 2 | 96.7% |
| **61** | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 2 | 2 | - | 100.0% |
| **610001** | Төсвийн байгууллага | 2 | 2 | - | 100.0% |
| **62** | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 29 | 28 | 1 | 96.6% |
| **620001** | Удирдах ажилтан | 8 | 8 | - | 100.0% |
| **620002** | Гүйцэтгэх ажилтан | 14 | 14 | - | 100.0% |
| **620003** | Үйлчлэх ажилтан | 6 | 6 | - | 100.0% |
| **620004** | Гэрээт ажилтан | 1 | - | 1 | 0.0% |
| **65** | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 29 | 28 | 1 | 96.6% |
| **650001** | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 11 | 11 | - | 100.0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **650009** | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 11 | 11 | - | 100.0% |
| **650010** | Гэрээт ажилтан | 1 | - | 1 | 0.0% |
| **650011** | Улс төрийн албан хаагч (УТ) | 6 | 6 | - | 100.0% |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон / мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 133,886.40 | 381,437.15 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 77,770.80 | 170,283.20 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 40,773.90 | 119,940.13 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 22,134.70 | 68,159.73 |
| **210101** | Үндсэн цалин | 5,059.30 | |
| **210102** | Нэмэгдэл | 17,075.40 | 68,159.73 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 2,760.40 | 8,498.78 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 2,104.10 | 5,786.89 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 184.3 | 685.23 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 177.5 | 342.62 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 38.8 | 336.81 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 255.6 | 1,347.22 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0 | 5,109.48 |
| **210302** | Түлш, халаалт | 0 | 5,109.48 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,998.00 | 535.67 |
| **210401** | Бичиг хэрэг | 0 | 535.67 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 1,998.00 | 680.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 41.4 | 680.00 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 41.4 | 1,192.95 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,839.40 | 1,192.95 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,139.40 | 35,763.51 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 700 | 35,763.51 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 36,996.90 | 50,343.07 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 36,996.90 | 32,158.29 |
| **213305** | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 32,158.29 |
| **213405** | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 36,996.90 | 18,184.78 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 56,115.60 | 18,184.78 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 56,115.60 | 211,153.95 |
| **222001** | Тоног төхөөрөмж | 0 | 211,153.95 |
| **223001** | Бусад хөрөнгө | 56,115.60 | 211,153.95 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 133,886.40 | 381,437.15 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 133,886.40 | 381,437.15 |
| **131104** | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 98,769.70 | 326,982.54 |
| **131105** | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35,116.80 | 54,454.61 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 3.1 Залруулсан алдаа

**Залруулсан алдаа байхгүй.**

Аудитаар нийт 22,114.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 22,114.5 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс материаллаг 22,114.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,085.1 мянган төгрөгөөр бага тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 118 хувиар давж биелсэн боловч 3 нэр төрлийн орлого 3-64 хувиар буюу 8,961.6 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх

2. **Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Орон нутгийн төсвийн ерөнхий орлогын гүйцэтгэлийг аймгийн Татварын газраас ирүүлсэн 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлээс 1 нэр төрлөөр 13,152.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д ”үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:*

Татварын байцаагчтай орлогын дүнг сар улирлаар тохирч байх, зөвлөмж өгөв.

3. ***Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Шилэн дансны цахим системд байршуулах 178 мэдээллээс 14 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх зөвлөмж өгөв.

4. ***Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

Илрүүлэлт: Засаг даргын захирамжаар баталсан дотоод хяналт, шалгалт явуулах ажлын хэсэг нь тайлант онд төлөвлөгөөний дагуу дотоод хяналт, шалгалт хийгээгүй байна.

Энэ нь Аж ахуй нэгж байгууллагын дотоод хяналт шалгалт явуулах тухай Засгийн газрын 311 дүгээр тогтоолтой нийцэхгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж</u>: Төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах, зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| **А** | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| **1** | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 1 | | 1 | | | | | |
| **2** | Засаг даргын тамгын газар | 1 | 1 | | | 1 | | | |
| **3** | Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан | 1 | | 1 | | | | | |
| **4** | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |
| **5** | Эмийн эргэлтийн сан | 1 | | 1 | | | | | |
| **6** | Орон нутгийн хөгжлийн сан | 1 | | 1 | | | | | |
| | **НИЙТ** | **6** | **1** | **5** | | **1** | | | |

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| **Алдааны товч утга** | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЭЭС | 1 | 93.4 | 1 | 93.4 | 1 | 93.4 | 1 | 93.4 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | 1 | 93.4 | 1 | 93.4 | 1 | 93.4 | 1 | 93.4 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

**/мянган төгрөгөөр/**

| **Зөрчлийн товч утга** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Засаг дарга | 3 | 22,114.5 | | | | | 3 | 22,114.5 | | | | |
| ИТХ | 3 | 1,700.2 | 1 | 75.0 | 1 | 1,088.2 | 1 | 537.0 | | | | |
| ЗДТГ | 2 | 2,785.0 | | | 1 | - | 1 | 2,785.0 | | | | |
| **ХХС** | 1 | 6,058.9 | | | 1 | 6,058.9 | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 9 | 32,658.6 | 1 | 75.0 | 3 | 7,147.1 | 5 | 25,436.5 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

**/мянган төгрөгөөр/**

| **Зөрчлийн товч утга** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Засаг дарга | 1 | | | | | | 1 | - |
| **ХХС** | 1 | - | | | | | 1 | - |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | 2 | - | | | | | 2 | - |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | 2 | - | | | | | 2 | - |